

ГЭРЭЛТЭЙ АМБДАРЬЯ



AND ENERGY



2023
4 САРЫН 22

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ



Орхон аймаг

Хурлын тов:

2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14.00 цагт

Хурал болох газар:

Орхон аймаг Баян-Өндөр сум Уртын гол баг Баянзам 3-4,6 тоотод байрлах үйлдвэрийн байранд цахим хэлбэрээр хуралдана

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэх өдөр:

2023 оны 04 дүгээр сарын 04 -ны өдрийн 17:00 цаг

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
3. Компанийн 2022 оны ноогдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах

**АГУУЛГА**

1. Компанийн танилцуулга
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай ТУЗ-ийн тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар, танилцуулах баримт бичгийн жагсаалт
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас

**ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ
БАРИМТ БИЧГҮҮД**

7. 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
Онцлох үйл явдлууд, санхүүгийн болон үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд, статистик мэдээ
8. САНХҮҮГИЙН ТАЙЛАН
Хараат бус аудиторын дүгнэлт, санхүүгийн тайлан болон хараат бус аудиторын тайлан
9. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
Засаглалын бүтэц, үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчид, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, хороодууд



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн
оноосон нэр

Анд-Энерги хувьцаат компани

Үйл
ажимлагааны
чиглэл

- LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл
- Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ
- Үйлдвэрлэлийн автоматжуулалт
- Гадаад Худалдаа

Албан ёсны
хаяг

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян-Зам 3-6 тоот
Утас: 77711010

И-мэйл: Info.andenergy@gmail.comВэб сайт: www.andenergy.mn

Фейсбүүк: And energy

Компанийн
удирдлага

ТУЗ-н дарга: Төмөрбатын Барс
Гүйцэтгэх захирал: Цэнд-Аюушийн
Гүррагчаа

Үүсгэн
байгуулагдсан
огноо

2011 оны 5-р сарын 23 өдөр

Ажилчдын тоо

25

Үйлдвэрлэлийн
хүчин чадал

Өдөрт 500-800 гэрэл үйлдвэрлэх

Дэлгүүрийн
тоо

Орхон аймаг-1:
Үйлдвэрийн
байранд
Улаанбаатар
хот-1: Мишээл
Барилгын Их
дэлгүүрийн 2
давхарт 87-р



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

ЭРХЭМ
ЗОРИЛГО

Мэдлэгт суурилсан үнэ цэнэтэй
бүтээлээр дэлхий ертөнцийг
гэрэлтүүлнэ

АЛСЫН ХАРАА

Бид Монгол улсын гэрэлтүүлгийн
хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно

ҮНЭТ ЗҮЙЛ

- Зөв засаглал;
- Эрдэм, мэдлэг;
- Шинэ санаачлага, бүтээлч байдал;
- Хамтын хүч

ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ЗАРЧИМ

- Харилцагч, хэрэглэгчийг
инээмсэглэлээр угтаж, итгэлээр үдэх
- Эрүүл аюулгүй орчинг бүрдүүлж,
ажилчдыг өсөн дэвших бодлого
баримтлан ажиллах
- Техник технологийн хөгжилтэй хөл
нийлүүлэн, байгаль орчинд ээлтэй
үйлдвэрлэлийг явуулах
- Хууль, дүрмийг чандлан сахиулан
ажиллах

УРИА ҮГ


ГЭРЭЛТЭЙ АМЬДАРЪЯ



МАНАЙ ХАРИЛЦАГЧИД



ОРХОН МОЛЛ
ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ



МАНАЙ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



LED Чийдэн
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 5Вт, 7Вт, 9Вт, 12Вт
Өнгө: Цагаан, шар




LED Нүдэн гэрэл
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 3Вт, 5Вт
Бүрхүүлийн сонголтой

LED Candle гэрэл /Абжурны/
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 5Вт
Гадна бүрхүүлийн сонголтой



LED Нүдэн гэрэл
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 3Вт, 5Вт
Гадна бүрхүүлийн сонголтой



LED Прожектор
Зориулалт: Талбайн гэрэлтүүлэг
Чадал: 50Вт, 100Вт, 150Вт
Хүчдэл: 85-265В



LED Түмпэн гэрэлтүүлэг
Зориулалт: Үйлдвэрийн /IP65/
Чадал: 50Вт, 100Вт, 150Вт
Хүчдэл: 85-265В

LED T8 төрлийн суурьтай гэрэлтүүлэг
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг
Чадал: 9Вт, 18Вт, 36Вт
Хүчдэл: 85-265В



LED T8 төрлийн гэрэл G13
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг
Чадал: 9Вт, 18Вт, 22Вт
Хүчдэл: 85-265В



ГУДАМЖНЫ LED гэрэлтүүлэг
Зориулалт: Автозамын гэрэлтүүлэг
Чадал: 50Вт, 80Вт, 150Вт
Хүчдэл: 85-265В



ГУДАМЖНЫ LED гэрэлтүүлэг
Зориулалт: Автозамын гэрэлтүүлэг
Чадал: 60Вт, 100Вт, 120Вт, 180Вт
Хүчдэл: 85-265В

LED таазны гэрэлтүүлэг /C32/
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг
Чадал: 32Вт
Хүчдэл: 85-265В



LED Таазны гэрэлтүүлэг /Панел/
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг
Чадал: 48Вт
Хүчдэл: 85-265В



LED Малчны гэрэл
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 10Вт
Туяаны /өнгө/ сонголтой
Хүчдэл: Тогтмол 12В



LED Аялагч гэрэл
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 3Вт
Хүчдэл: Тогтмол 5В

**“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 23/06

Орхон аймаг

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
цахим хэлбэрээр хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.4 дэх заалтууд, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалтууд, 64 дүгээр зүйлийн 64.1 дах заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, дахь заалт, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, “Анд-Энерги” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.9 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Анд Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 сарын 22-ны өдрийн Бямба гарагийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах үйлдвэрийн байранд цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаатай холбогдуулан **MI SURVEY** программыг цахим бүртгэл, санал хураалт явуулахад ашиглахыг зөвшөөрсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 3.1 Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
 - 3.2 Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
 - 3.3 Компанийн 2022 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
4. Хувьцаа эзэмшигчийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-н нэгдүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргаж холбогдох баримтын хамт 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдөрт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон Улаанбаатар үнэт цаасны биржид хүргүүлэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ээр баталж, 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар үнэт цаасны бирж болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, зарыг давтан 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр анх мэдээлсний дагуу олон нийтэд хурлын зарыг дахин хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 дүгээр сарын 4-ны өдрийн 17:00 цаг байхаар тогтоосугай.

7. Танилцах баримт бичгийн жагсаалт, Ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталж, 2023 оны 3 сарын 21-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчид болон тэдгээрт үйлчилж буй брокер, диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлэх, мөн тухайн өдрөөс эхлэн 09:00-17:00 цагийн хооронд Анд-Энерги ХК-ийн үйлдвэрийн байранд ирж танилцах болон www.andenergy.mn цахим хуудсаар орж хурлын материалыг электрон хэлбэрээр татан авч танилцах боломжийг бүрдүүлсүгэй.
8. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №3, Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тогтоолын төслийг Хавсралт №4, Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тогтоолын төслийг Хавсралт №5-аар тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдээс хурлын санал хураалтыг <https://hural.andenergy.mn> веб хаягаар 2023 оны 4 сарын 22-ны өдрийн 15:30 цаг хүртэл урьдчилан болон Хурлын үеэр тус тус цахимаар хүлээн авна.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Т.Барс, тооллогын комиссын даргаар Х.Батсуурь, гишүүдээр М.Эрдэнэцэцэг, Г.Дэлгэрмаа нарыг тус тус томилсугай.
11. Ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Ц.Гүррагчаа, гишүүдээр Б.Тогос-Эрдэнэ, Д.Ундармаа, А.Алтансүх, Э.Ариунсайхан, М.Дэлгэрмаа нарыг тус тус томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийг хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох дүрэм журамд нийцүүлэн ажиллах, хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг хурлын дарга Т.Барс, Ц.Гүррагчаа нарт даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг хурлын даргад зөвшөөрсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА

Т.БАРС

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр Хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	АНД-ЭНЕРГИ ХК
Хаяг:	Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот Утас: 77711010
Хурал хуралдах өдөр, цаг:	2023 оны 4 сарын 22-ны өдөр, 14:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян Зам 3-4,6 тоотод байрлах “Анд-Энерги” ХК-ийн өөрийн байр www.facebook.com/AndEnergy
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2023 оны 3 сарын 11
Олон нийтэд зарлах огноо:	2023 оны 3 сарын 16 2023 оны 3 сарын 31
Бүртгэлийн өдөр:	2023 оны 4 сарын 4
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, диллерийн компанид хүргүүлэх огноо:	2023 оны 3 сарын 21
Хүргүүлсэн огноо:	2023 оны 3 сарын 21
Хурлын даргын нэр:	Төмөрбат овогтой Барс
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Тооллогын комиссын дарга: Х.Батсуурь, Тооллогын комиссын гишүүн: МЭрдэнэцэцэг, Г.Дэлгэрмаа
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Хавсралтаар
Баримт, бичгийн хуудасны тоо: ширхэг
 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /Ц.ГҮРРАГЧАА/

2023 оны 3 сарын 11-ны өдөр

Дээрх мэдээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.

“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 11-ний
өдрийн 23/06 тоот тогтоолын Хавсралт №1

“АНД ЭНЕРГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Анд Энерги” ХК нь ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 11-ний өдрийн 23/06 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулах болсныг зарлаж байна.

Компанийн оноосон нэр: Анд-Энерги ХК

Хурал хуралдуулах өдөр, цаг: 2023 оны 4 сарын 22-ны өдрийн 14:00 цагт

www.facebook.com/AndEnergy цахим хуудсаар хуралдана.

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
3. Компанийн 2022 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2023 оны 4 сарын 4-ний өдөр

Хувьцаа эзэмшигч та 2023 оны 3 сарын 21-ны өдрөөс 2023 оны 4 сарын 21-ны өдөр хүртэл ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот ажлын байранд хүрэлцэн ирэх эсвэл компанийн Andenergy.mn болон өөрийн харилцдаг брокер диллерийн цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ ХУРЛЫН БАРИМТ БИЧГҮҮД:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл

САНАЛЫН ХУУДАС ХҮЛЭЭН АВАХ СҮҮЛИЙН ХУГАЦАА:

Хувьцаа эзэмшигчдээс ээлжит хурлын санал хураалтыг <https://hural.andenergy.mn> веб хаягаар 2023 оны 04 сарын 22-ний өдрийн 15:30 цаг хүртэл урьдчилан цахимаар болон хурлын үеэр цахимаар тус тус хүлээн авна.

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот

Утас: 77711010, 88351298, 99363623,

Имэйл хаяг: erdenetledandenergy@gmail.com

"Анд-Энерги" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 11-ний
өдрийн 23/06 тоот тогтоолын Хавсралт №2

**“АНД-ЭНЕРГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл
1	“Анд-Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 11-ний өдрийн тогтоол
2	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
4	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
5	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл
6	Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар
7	Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
8	Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
9	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлт
10	Компанийн ногдол ашиг хуваарилах тухай гаргасан ТУЗ-ийн тогтоол шийдвэр

АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал хуралдах огноо: 2023 оны 4 сарын 22-ны өдрийн 14:00 цагт
Хурлын үргэлжлэх нийт хугацаа: 1 цаг 40 минут

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Хурлын ирцийг бүртгэх	10 минут	Зохион байгуулах комисс
2.	Хурлын ирцийг мэдээлэх	5 минут	Тооллогын комисс
3.	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах, хэлэлцэх асуудлуудыг танилцуулах	10 минут	Хурлын дарга Т.Барс
4.	Компанийн 2022 оны үйл ажиллагааны товч тайланг танилцуулах	15 минут	Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа
5.	Компанийн 2022 оны үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Т.Барс
6.	Компанийн 2022 оны санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Т.Барс
7.	Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол шийдвэрийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Т.Барс
8.	Асуулт хариулт	15 минут	Зохион байгуулах комисс
9.	Хурлын завсарлага, санал тоолох	15 минут	Тооллогын комисс, Зохион байгуулах комисс
10.	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах /ХЭХурлын тогтоол/	10 минут	Тооллогын комисс, Хурлын дарга Т.Барс
11.	Хурлыг хаах	5 минут	Хурлын дарга Т.Барс

"Анд-Энерги" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 11-ний
өдрийн 23/06 тоот тогтоолын Хавсралт №3

АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ОВОГТОЙ

Регистрийн дугаар:

Хувьцаа эзэмшигчдийн хурал: *Ээлжит*

Санал өгөх хувьцааны тоо

Үнэт цаасны компанийн нэр:

Анд-Энерги ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 сарын 22-ны өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах "Анд-Энерги" ХК-ийн өөрийн байранд

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай			
2	Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай			

Санал өгсөн түүх

IP хаяг	Хөтөч	Хост	Огноо
1			

2023 оны 4 сарын 22-ны өдөр

"Анд-Энерги" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 11-ний
өдрийн 23/06 тоот тогтоолын Хавсралт №4

[Төсөл]

"АНД-ЭНЕРГИ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 сарын 22 өдөр

Дугаар 01

Орхон аймаг

Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, түүнд
хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2023 оны 4 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Анд-Энерги" ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.БАРС

"Анд-Энерги" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 11-ний
өдрийн 23/06 тоот тогтоолын Хавсралт №5

[Төсөл]

"АНД-ЭНЕРГИ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 сарын 22 өдөр

Дугаар 02

Орхон аймаг

Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн
талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2023 оны 4 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Анд-Энерги" ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Хараат бус аудитын тайлан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.БАРС

**„АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 23/04

Орхон аймаг

**Компанийн 2022 оны үйл ажиллагааны
тайланд дүгнэлт өгөх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.6.12 дахь заалт, 2023 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг „Хангалтай” хэмээн дүгнэсүгэй.
2. 2022 оны үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж танилцуулахыг гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Т.БАРС

„АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 23/05

Орхон аймаг

Компанийн 2022 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.6.12 дахь заалт, 2023 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайланг 51 хувиар „Хангалтай” хэмээн дүгнэсүгэй.
2. 2022 оны санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж танилцуулахыг Аудитын хороо /Д.Мөнхбат/-нд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Т.БАРС

„АНД-ЭНЕРГИ“ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 23/02

Орхон аймаг

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5 дахь заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. „Анд-Энерги“ ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 80 мөнгө буюу нийт 62,456,606.4 төгрөг (Жаран хоёр сая дөрвөн зуун тавин зургаан мянга зургаан зуун зургаан төгрөг дөчин мөнгө)-ийн ногдол ашгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөртэй нэгэн ижил байхаар тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, „Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв“ ХХК-аар дамжуулан Хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2023 оны 09 дүгээр сарын 30-ны дотор олгохыг Гүйцэтгэх захирал /Ц.Гүррагчаа/-д даалгасугай.
4. Уг тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн дарга /Т.Барс/ өөртөө үлдээсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА

Т.БАРС



ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГҮҮД





2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН



ТҮҮХЭН ЗАМНАЛ



СУРГАЛТ, ХӨГЖИЛ

- Харилцаа хандлага хувь хүний хөгжлийн сургалт
 - Өглөөний менежер хувь хүний хөгжлийн сургалт
 - Бизнесийн дижитал хурдасгуур, Chatbot-ийн сургалт
 - Үйлдвэрлэлийн менежмент цуврал сургалт
 - Бизнес төлөвлөгөө боловсруулах нь цуврал сургалт
 - Илтгэх урлагт суралцах нь хувь хүний хөгжлийн сургалтууд
-
- Жолооны C ангилал олгох сургалт
 - Сагстай өргөгчийн операторын сургалт
 - Олон улсын сертификатай гагнуурчины мэргэжил олгох сургалт
 - ХАБЭА хууль тогтоомж, түүнтэй холбоотой заавар дүрэм журмууд
 - Autocat, 3D зургийн програмын сургалт



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“Бат –Илч” ХХК-ний албан ёсны гэрээт борлуулагч болж EKF болон бусад брэндийн цахилгаан угсралтын бүтээгдэхүүнүүдийг Монгол улсад борлуулах онцгой эрхтэйгээр борлуулж эхэлсэн. Үүний дүнд 622 ширхэг бүтээгдэхүүнийг борлуулж 31,911,903₮ орлого олж чадсан байна.




Барилга хот байгуулалтын яам, Орхон аймгийн ЗДТГ хамтран зохион байгуулсан “Дахин төлөвлөн барилгажуулах дэд бүтэцжүүлэх төслүүд” улсын анхдугаар чуулга уулзалт, зөвлөгөөнд бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулан оролцсон. Үүний хүрээнд бид Эрдэнэт хотод шинээр баригдаж буй барилгуудад өөрийн компанийг танилцуулж бүтээгдэхүүн үйлчилгээгээ санал болгосон.




ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Катодын 99.999% зэс, зэс утас үйлдвэрлэгч Эрдмин ХХК -ийн албан ёсны гэрээт борлуулагчаар хамтран ажиллаж цахилгааны кабель утас, уртасгагч залгуур борлуулж эхэлсэн. Үүний дүнд 92 ширхэг уртасгагч залгуур, 154,550м цахилгааны кабель утас борлуулж 216,410,357₮ орлого олж чадсан байна.



"Power Scada Operation" программ хангамжийн ашиглалт болон туршлага солилцох өдөрлөгийг Шнайдер Электрик Монголиа ХХК-тай хамтран амжилттай зохион байгуулсан. Үүний хүрээнд:

- Гэрлийн хэмнэл ХХК
- Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ /төвийн бүс/
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ
- Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК
- Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК
- Ш. Отгонбилэгийн нэрэмжит "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль – ийн инженер техникийн мэргэжилтнүүдэд бүтээгдэхүүнээ таниулж хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан



2022 ОНД БИД



Орхон аймгийн Булаг багийн
гэрэлтүүлгийн ажил



Орхон аймгийн "Эрдэнэт
өртөө"-ний гэрэлтүүлгийн ажил



2022 ОНД БИД

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 12 дугаар цэцэрлэгийн гадна фасадны гэрэлтүүлгийн ажил



Орхон аймгийн нутаг дэвсгэр дэх 6-0.4кВ-ын ХТП-275-аас ХТП-276 дэд станц хүртэлх 6кВ-ын кабель шугам татах ажил

2022 ОНД БИД



Шахмал түлшний үйлдвэрийн
холбоо дохиололын монтаж хийх ажил



Нийт 24,9мкв үсгэн хаяг

- Ойн генетик нөөцийн Эрдэнэт төв
- Орхон аймаг Баян-Өндөр сумын 7 дугаар цэцэрлэг
- „Мэргэн” ресторан, супермаркет



2022 ОНД БИД

„Эргэлтийн Ус Хангамжийн Хэсгийн Ebara маркийн насосын давтамж хувиргагчийн угсралт, суурилуулалт, технологийн шкаф болон цахилгааны удирдлагын шу-1 шкаф”-ыг шинэчлэн солих ажлын хүрээнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-н УХЦ-ийн ЦУХХ-н 2,3,4-р ус өргөх станцын насос №5-н технологийн хамгаалалтын самбарууд-3ш
- ЭУХХ-н цахилгааны удирдлагын ШУ-1 шинэчлэн солих ажлын хүрээнд:
- 3ш удирдлагын шкаф
- Насосыг давтамж хувиргуураар удирдах шкаф -1ш нийт 7ш удирдлын шкаф монтаж хийж угсарлаа.



Санхүүгийн болон үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэл		
		2020	2021	2022
Гэрлийн жижиглэнгийн борлуулалт	Сая.төг	200.2	127.8	199.0
Гэрлийн бөөний борлуулалт		889.6	839.1	407.7
Цахилгаан тоног төх.ийн худалдаа		444.3	512.6	631.9
Цахилгаан тоног төхөөрөмж, угсралт суурилуулалт, Автоматжуулалтын ажил		423.2	473.4	768.03
Гэрэлтүүлгийн угсралт суурилуулалт		248.5	77.9	78.14
Нийт борлуулалсан орлого		2205.8	2030.8	2084.7
Борлуулалсан бүтээгдэхүүний өртөг		1312.4	1266.5	1.400
Үйл ажиллагааны зардал		893,4	765	573.9
Цэвэр ашиг		24.6	13.9	26.2
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо		ширхэг	25,731	21,914
Борлуулсан бүтээгдэхүүний тоо	37,243		21,690	11,966
Үйлдвэрлэлийн хүчин чадал	500-800		500-800	500-800
Ажил	8		17	20
Цахилгаан тоног төхөөрөмж нийлүүлэлт	3		2	1

СТАТИСТИК МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Цэвэр ашиг
26,51



Төлсөн татвар
151,20



Үндсэн хөрөнгө
1,644,01

БОРЛУУЛАЛТ



Цахилгаан тоног
төхөөрөмж угсралт
Автоматжуулалт
768.03



Гэрэлтүүлгийн
ажил
78.14



Шууд худалдаа
631.90



Гэрэл үйлдвэрлэл
606.69


АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛ



Үйлдвэрлэсэн гэрэл- 124,84
Үсгэн хаяг- 24,9мкв



Цахилгаан тоног
төхөөрөмж, угсралт,
Автоматжуулалтын ажил- 15



Гэрэлтүүлгийн ажил-5



СТАТИСТИК МЭДЭЭ

ХҮНИЙ НӨӨЦ

НИЙТ АЖИЛТНЫ ТОО /25/

ЗААА-5



МБА- 8



СХҮА-7




СТА-4



АЖИЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



АЖИЛЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСЖИЛТ



**АЖИЛЧДЫН АЛБАН
ТУШААЛЫН ХАРЬЦАА**





2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН





САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БОРЛУУЛАЛТЫН ОРЛГО /сая.төг/




ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛЫН ТАТАН АВАЛТ /сая.төг/

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ /ширхэг/




САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЦЭВЭР АШИГ /сая.төг/



ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, ХУРААМЖ /сая.төг/



Анд энерги ХК



“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ” ХХК

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨ

Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот
Улаанбаатар хот, Монгол улс, 16010, Утас: 11-976-99046494

Огноо:2023-02-16

№ 23/04

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**АНД ЭНЕРГИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд****Дүгнэлт**

Бид 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн АНД ЭНЕРГИ ХК компанийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар АНД ЭНЕРГИ ХК компанийн 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж (эсвэл эдгээрийн талаар үнэн бөгөөд зөв ойлгоц өгч) байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохимжтой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторчуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогч

Гүйцэтгэх захирал

Ч.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот

Утас: 976 – 9904 6494; 86030388

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31	Тэмдэглэл	21.12.31	22.12.31
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгөн хөрөнгө	4	13,288,511.33	9,857,928.02
Дансны авлага	5	299,802,716.70	630,103,151.61
Татвар ба НДШ-ийн авлага	6	488,283.00	575,153.54
Бусад авлага	7	2,481,536.95	65,423,403.10
Бараа материал	8	349,216,729.56	560,936,099.26
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9	214,732,737.56	60,287,115.17
Эргэлтийн хөрөнгийн дүн		880,010,515.10	1,327,182,850.70
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	10	1,667,908,733.11	1,571,727,566.43
Биет бус хөрөнгө	11	67,220,278.84	65,788,083.83
Биологийн хөрөнгө	12	6,500,000.00	6,500,000.00
Үндсэн хөрөнгийн дүн		1,741,629,011.95	1,644,015,650.26
Нийт хөрөнгө		2,621,639,527.05	2,971,198,500.96
ӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	13	24,070,127.08	90,529,970.39
Татварын өр	14	19,185,426.28	55,920,708.15
НДШ-н өглөг	15	26,249,420.95	10,294,698.62
Богино хугацаат зээл	16	51,247,472.37	469,322,129.93
Хүүний өглөг	17	434,036.86	3,132,505.07
Урьдчилж орсон орлого	18	22,486,520.00	2,112,480.00
Урт хугацаат зээл	19	406,213,991.47	241,683,706.60
Өр төлбөрийн дүн		549,886,995.01	872,996,198.76
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувийн өмч	20	78,070,758.00	78,070,758.00
Нэмж төлөгдсөн капитал	21	1,470,540,877.00	1,470,540,877.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22	264,224,371.82	264,224,371.82
Хуримтлагдсан ашиг		258,916,525.22	285,366,295.38
Эздийн өмчийн дүн		2,071,752,532.04	2,098,202,302.20
Нийт эздийн өмч ба өр төлбөр		2,621,639,527.05	2,971,198,500.96

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ОРЛОГЫН ТАЙЛАН

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31

Үзүүлэлт	Тэмдэглэл	21.12.31	22.12.31
Борлуулалт	23	2,030,853,671.20	2,084,776,060.63
ББӨ	24	1,266,555,649.99	1,400,284,283.13
Нийт ашиг		764,298,021.21	684,491,777.50
Бусад орлого	25	16,709,535.45	18,111,719.54
Борлуулалт, маркетингийн зардал	26	121,180,256.64	132,175,306.34
Ерөнхий ба удирдлагын зардал	27	541,032,819.72	438,777,416.12
Санхүүгийн зардал	28	78,359,247.65	74,790,166.70
Бусад зардал	29	24,813,032.96	28,866,509.27
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	30	654.28	2,864.73
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз	31	(198,607.00)	1,433,160.52
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз гарз	32	-	(287,475.73)
Татвар төлөхийн өмнөх ашиг		15,424,246.97	29,142,648.13
Орлогын татварын зардал	33	1,542,424.70	2,914,264.82
Татварын дараах ашиг		13,881,822.27	26,228,383.31
Цэвэр ашиг		13,881,822.27	26,228,383.31

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31

Үзүүлэлт	Эздийн өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт
2020 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	279,569,146.26	2,092,405,153.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(34,534,443.32)	(34,534,443.32)
Залруулсан үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	245,034,702.94	2,057,870,709.76
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	13,881,822.27	13,881,822.27
2021 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	258,916,525.21	2,071,752,532.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	221,386.86	221,386.86
Залруулсан үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	259,137,912.07	2,071,973,918.89
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	26,228,383.31	26,228,383.31
2022 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	285,366,295.38	2,098,202,302.20

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Анд энерги ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31	21.12.31	22.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	2,189,615,949.70	2,119,212,437.85
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,609,701,411.70	1,303,709,376.58
Бусад мөнгөн орлого	579,914,538.00	815,503,061.27
Мөнгөн зарлагын дүн	2,051,512,325.19	2,332,283,589.55
Ажилчдад төлсөн	247,777,065.90	201,052,385.24
Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн	82,122,134.30	126,734,625.65
Бараа материал худалдан авахад төлсөн	1,063,031,998.00	1,202,909,839.19
Ашиглалтын зардалд төлсөн	8,818,377.70	24,181.81
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,442,107.70	8,482,512.81
Хүүний төлбөрт төлсөн	77,925,210.80	71,657,661.63
Татварын байгууллагад төлсөн	210,781,974.70	133,903,452.63
Даатгалын төлбөрт төлсөн	1,256,910.00	-
Бусад мөнгөн зарлага	327,356,546.09	587,518,930.59
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	138,103,624.51	(213,071,151.70)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	7,000,000.00	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,000,000.00	-
Мөнгөн зарлагын дүн	76,900,409.00	202,201,673.84
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,285,000.00	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,232,224.00	-
Бусад олгосон зээл урьдчилгаа	58,383,185.00	202,201,673.84
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	(69,900,409.00)	(202,201,673.84)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	722,870,000.00	897,508,935.33
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	722,870,000.00	897,508,935.33
Мөнгөн зарлагын дүн	803,443,658.40	485,666,693.10
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	803,443,658.40	485,666,693.10
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(80,573,658.40)	411,842,242.23
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(12,370,442.89)	(3,430,583.31)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,658,954.22	13,288,511.33
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,288,511.33	9,857,928.02

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.




КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Анд-Энерги” ХК нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын сонирхлын тэнцвэрийг хангах, компанийн үйл ажиллагааны бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэгдсэн дараах засаглалын бүтэц, зохион байгуулалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



Манай компани Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, гаднын компаниудын сайн засаглалын туршлагаас суралцан Сайн засаглалыг нэвтрүүлэх, компанийн засаглалаар манлайлахаар чармайн ажилмаж ирсэн бөгөөд Компанийн засаглалыг хөгжүүлэх ажлын хүрээнд Монголын хувьцаат компаниудын холбоо ТББ-ийн гишүүнээр элсэн харилцан туршлага солилцон ажилмаж байна.

Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах журмуудыг мөрдөн ажилмаж байна.

- ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- ✓ Аудитын хорооны журам
- ✓ Нэр дэвшүүлэх хорооны журмыг шинэчлэн батлах
- ✓ Цалин, урамшуулмын хорооны журмыг батлах
- ✓ Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журам батлах
- ✓ Мэдээллийн үйл ажиллагааны журам.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Компанийн тухай хуульд заасны дагуу 2022 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 1 удаа зарлан хуралдуулж компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл (ТҮЗ)-ийн дүгнэлт, ТҮЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, ногдол ашиг хуваарилах эсэх талаар (ТҮЗ)-ийн шийдвэрийг танилцуулах зэрэг асуудлыг хэлэлцэн нийт 3 тогтоол гаргасан.

„Анд-Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 сарын 23-ны өдөр компанийн албан ёсны пэйж хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр нээлттэй зохион байгуулсан. Хуралд „Анд-Энерги” ХК-ийн ТҮЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комисс болон тус компанийн 24 хувьцаа эзэмшигчид оролцлоо.

2022 оны 4 сарын 4-ний хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийн байдлаар нийт 575 хувьцаа эзэмшигчид „Анд-Энерги” ХК-ийн 78,070,758 ширхэг хувьцааг эзэмшиж байгаагаас тус ээлжит хуралд 67.82% буюу 52,944,700 ширхэг хувьцааг эзэмшдэг 24 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц бүрдэж хурал хүчин төгөлдөр болов.



Хурлийн дэгийн дагуу хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулж, ТҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга болон асуулт хариулт, санал хураалтын үйл ажиллагаа явагдсанаар дараах шийдвэр гарсан. Үүнд:

1. Анд-Энерги ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.
2. Анд-Энерги ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Хараат бус аудитын тайлан дүгнэлтийг „Хангалтай” үнэлгээгээр батлав.
3. Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдэд
 1. Далхаа овогтой Мөнхбаяр
 2. Төмөрбат овогтой Барс
 3. Ганхуяг овогтой Түвшин
 4. Цэнд-Аюуш овогтой Гүррагчаа
 5. Дагвапунцаг овогтой Алтангэрэл

6. Эрдэнэбаяр овогтой Мягмардорж


Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдэд

1. Мөнхжаргал овогтой Ганбат
2. Дүүсүрэн овогтой Мөнхбат
3. Дашдаваа овогтой Боргио нарыг тус тус

2022 оны 4 сарын 23-ны өдрөөс эхлэн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгов.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО
78 070 758

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТОО
575

/2022.04.05-ны өдрийн
байдлаар/

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

№	Хувьцаа эзэмшигч	Тоо ширхэг	Эзэмшигчийн хувь
1	Т.Барс	12 908 375	16.5%
2	Ц.Гүррагчаа	12 830 375	16.4%
3	Д.Мөнхбаяр	12 908 875	16.5%
4	Г.Түвшин	12 908 375	16.5%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах ердийн болон хараат бус гишүүд шинээр сонгогдож, 2022 оны 5 дугаар сараас эхлэн доорх шинэчилсэн баг бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.



ТУЗ-ийн дарга
Т.Барс
Уул уурхайн цахилгаан
тоног төхөөрөмж,
ашиглалтын магистр

„Анд-Энерги“ ХК-ийн
ТУЗ-ийн дарга



ТУЗ-ийн ердийн гишүүн
Д.Мөнхбаяр

Инженер



ТУЗ-ийн ердийн гишүүн
Т.Түвшин
Байгалийн нөөц,
технологийн шинжлэх
ухааны магистрантур

„Эрдэнэт Үйлдвэр“ ТӨҮГ-т
Автоматжуулалтын инженер



ТУЗ-ийн ердийн гишүүн
Ц.Гүррагчаа
Уул уурхайн цахилгаан
тоног төхөөрөмж,
ашиглалтын магистр

„Анд-Энерги“ ХК-ийн
Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн
Э.Мягмардорж
Хууль зүйн ухааны магистр
Удирдахуйн ухааны
магистр

Өмгөөлөгч



ТУЗ-ийн ердийн гишүүн
Д.Алтангэрэл
Цахилгаан механикч,
инженер

„АЦХ“ ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



ТУЗ-ийн хараат бус гишүүн
М.Ганбат
Эдийн засагч

Орхон аймаг дахь
худалдаа, аж үйлдвэрийн
танхимын дарга



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Д.Боргио
Төрийн удирдлагын магистр



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Д.Мөнхбат
Бизнесийн удирдлагын
магистр

Шинэ сэргэлтийн бодлогын
хурдасгуур төвийн ахлах
мэргэжилтэн

ТУЗ-ийн хурал нь 7 удаа, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 2 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хурал 1 удаа тус тус хуралдсан.

ТУЗ-ийн хуралаар нийт 18 асуудлыг хэлэлцсэнээс хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн олонхийн саналаар 18 тогтоол баталсан байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах болон бэлтгэл ажилтай холбоотой 3 тогтоол;
- Компани, ТУЗ, ТУЗ-ийн хороод, бүтэц зохион байгуулалттай холбоотой 7 тогтоол;
- Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүжилт, удирдлага зохион байгуулалттай холбоотой 8 тогтоол тус тус гаргажээ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХОРООД

Шинээр сонгогдсон ТУЗ нь аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшуулмын хороодыг 2022 оны 5 дугаар сард байгуулсан.

АУДИТЫН ХОРОО

Аудитын хорооны гишүүдээр Төмөрбат овогтой Барс, Мөнхжаргал овогтой Ганбат, хорооны даргаар Дүүсүрэн овогтой Мөнхбат;

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр Эрдэнэбаяр овогтой Мягмардорж, Дүүсүрэн овогтой Мөнхбат, хорооны даргаар Дашдаваа овогтой Боргио;

ЦАЛИН УРАМШУУЛМЫН ХОРОО

Цалин урамшуулмын хорооны гишүүдээр Дашдаваа овогтой Боргио, Далхаа овогтой Мөнхбаяр, хорооны даргаар Мөнхжаргал овогтой Ганбат нарыг тус тус томилсон.

2022 оны 6 дугаар сараас ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Б.Тогос-Эрдэнэ үргэлжлүүлэн томилогдож, Компанийн тухай хууль, компанийн дүрмийн заалтуудын хүрээнд ТУЗ, ТУЗ-ийн хороод болон хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах, бүртгэл, тэмдэглэл, анкет хөтлөх зэрэг ажлуудыг хариуцан ажиллаж байна.



Тэрэлтэй
амьдаруулаа





УТАС: +976 77711010



И-МАЙЛ: info@andenergy.mn



www.andenergy.mn



And Energy



Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын
гол баг, Баян зам 3-6 тоот



Борлуулах цэг:

Эрдэнэт хот

- Үйлдвэрийн байр, нэрийн дэлгүүр

Улаанбаатар хот

- Мишээл экспо барилгын их дэлгүүр
87-р павилон

